



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/320

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7, 2.9 дэх заалт, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2018 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа болон давтан олгох 9 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081326

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 03 өдрийн
А/320 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АНХ УДАА БОЛОН
ДАВТАН ОЛГОХ ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН
ЧИГЛЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Үйл ажиллагаа эрхлэх хугацаа
1.	Бэ Сүн Хө Bae Seung Ho	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Агь Манба” хувийн хэвшлийн ортой эмнэлэг	ГЭ0002086	Уламжлалт анагаах ухаан судлал	Эмчлэх	2018.08.06- 2018.08.11 /6 хоног/
2	Квон У Санг Kwon Oh Sang	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Агь Манба” хувийн хэвшлийн ортой эмнэлэг	ГЭ0002087	Уламжлалт анагаах ухаан судлал	Эмчлэх	2018.08.06- 2018.08.11 /6 хоног/
3	И Гил Хэ Yi Gilhee	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Агь Манба” хувийн хэвшлийн ортой эмнэлэг	ГЭ0002088	Уламжлалт анагаах ухаан судлал	Эмчлэх	2018.08.06- 2018.08.11 /6 хоног/
4	Шин Хюн Сүн Shin Hyun Soon	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Агь Манба” хувийн хэвшлийн ортой эмнэлэг	ГС0000262	Сувилахуй судлал	Сувилах	2018.08.06- 2018.08.11 /6 хоног/
5	Вүү Кеон Чеол Woo Keoncheol	Бүгд Найрамдах Солонгос Улс	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	ГЭ0002089	Нүүр ам судлал	Эмчлэх	2018.08.19- 2018.08.23 /5 хоног/

6	Сонг Дүкэ Хан Song Duke Han	Бүгд Найрамдах Солонгос Улс	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	ГЭ0002090	Нүүр ам судлал	Эмчлэх	2018.08.19- 2018.08.23 /5 хоног/
7	Ким ЁукЁунг Kim Youkyoung	Бүгд Найрамдах Солонгос Улс	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	ГЭ0002091	Нүүр ам судлал	Эмчлэх	2018.08.19- 2018.08.23 /5 хоног/
8	Яанг Вэнши Yang Wenxi	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	“Цэцэг хайрхан” өрхийн эрүүл мэндийн төв Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв	ГЭ0002092	Уламжлалт анагаах ухааны дотор судлал	Эмчлэх	2018.08.15- 2018.08.30 /16 хоног/
9	Бао Нариси Bao Narisi	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	“Цэцэг хайрхан” өрхийн эрүүл мэндийн төв Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв	ГЭ0002093	Уламжлалт анагаах ухааны арьс судлал	Эмчлэх	2018.08.15- 2018.08.30 /16 хоног/